



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/116

Шивээговь сум

Газар эзэмших эрхийн зориулалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.6, 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.2, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 08 дугаар “Төлөвлөгөө батлах тухай” тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны А/187 дугаар “Журам батлах тухай” тушаалын 5.4.4, 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тахилтстар ХХК нь Шивээговь сумын 2 дугаар баг, Өехийн хонхорт байрлах “Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар”-ын зориулалттай 5 га газрынхаа газар эзэмших эрхийн зориулалтад өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тул газрын зориулалтыг “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор” болгон өөрчилж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшиж буй газрынхаа орчныг эрүүл, хог хаягдалгүй байлгаж, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, ногоон байгууламжийг бий болгон Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг Тахилтстар ХХК-ийн захирал (Д.Түмэннасан)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмшигч Тахилтстар ХХК-ийн захирал Д.Түмэннасантай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 122 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42123 370